



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 11 сарын 16 өдөр

Дугаар 123

Эрдэнэт

Ээлжит хуралдаан зарлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх заалтыг үндэслэн Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 7 дахь удаагийн сонгуулийн Ээлжит IV хуралдааныг 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Эрдэнэт хотод хуралдуулж, дараах асуудал хэлэлцүүлэхээр тогтоосугай.

1. Аймгийн эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн урьдчилсан гүйцэтгэл, 2017 онд аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийн тухай

2. Аймгийн 2017 оны төсөв батлах тухай

3. Аймгийн хэмжээнд газрын харилцааны талаар 2016 онд баримталсан бодлогын хэрэгжилт, 2017 онд баримтлах бодлогын тухай

4. Аймгийн ИТХ-ын байгууллагын 2016 онд хийсэн ажлын тайлан, илтгэл

Хоёр. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Ээлжит IV хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтын ёсоор баталсугай.

Гурав. Аймгийн ИТХ-ын Ээлжит IV хуралдааны бэлтгэл хангаж хуралдуулахыг Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга П.Пүрэвлхагвад даалгасугай.



ДАРГА

П.ПҮРЭВЛХАГВА